

**Б.ЛХАГВАЖАВ: АМ.ДОЛЛАРЫН ХАНШ 1.5 - 2 ХУВИАР ЧАНГАРСАН
БАЙХАД БЕНЗИНИЙ ҮНЭ ДАРУЙ 15 - 16 ХУВИАР НЭМЭГДСЭН**

Сүүлийн үед олны анхаарлын төвд байгаа ам.долларын ханш чангарсан, бензиний үнэ өссөн асуудлаар Монголбанкны Олон нийттэй харилцах хэлтсийн захирал Б.Лхагважавтай ярилцлаа.

- Нефть импортлогчид валютын ханшийн өсөлтийг далимдуулан үнээ өсгөсөн үү?

- Аливаа бизнест өөрийн цикл байдаг. Андуураагүй бол нефть импортлогчдын бизнес 2 долоо хоногийн циклтэй байдаг гэсэн. Гэтэл үйл явдал өрнөсөн 2 долоо хоногийн дотор долларын ханш 1.5-2 хувиар чангарсан байхад бензиний үнэ даруй 15-16 хувиар нэмэгдсэн байгаа юм. Нефть, бензинийхээ үнийг нэмэх шаардлага анхнаасаа импортлогчдод байсан бол асуудлаа үндэслэлийн хамт тухай бүр Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх ёстой болохоос биш гэнэт огцом нэмэгдүүлчихээд шалтгааныг нь шал өөр газраас эрэх хэрэггүй байсан юм. Аливаа бизнес ашгийн төлөө явдаг нь үнэн. Гэхдээ нөгөө талд нь нийгмийн хариуцлага гэдэг зүйл бий. Ийм хариуцлагагүй алхам улс төр, эдийн засгийн тогтворгүй байдалд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, цаашилбал нийгмийн эмх замбараагүй байдалд ч хүргэж мэднэ.

- Ханш хөдлөх тоолонд экспортлогчид, импортлогчид тодорхой хэмжээний эрсдэл хүлээх нь ойлгомжтой. Тэгэхээр тэр эрсдлийг бууруулах арга зам байх уу?

- Байлгүй яахав. Ханшийн эрсдлийг санхүүгийн дериватив хэрэгслүүдийн тусламжтайгаар бууруулах бүрэн боломжтой. Дериватив захыг хөгжүүлэх үүднээс Монголбанк төгрөг-долларын, төгрөг-юаний своп хийх журмуудыг батлан банкуудад боломжийг нь олгосон байгаа. Мөн энэ сэдвээр Монголбанкнаас удаа дараа сургалт зохион байгуулсаар ирсэн. Бүтэн жил зургаан сарын өмнөөс ханшийн эрсдлээ зохицуулах боломжийг олгосоор байхад манай санхүүгийн захын тоглогчид төдийлөн ойшоохгүй ирсэн нь харамсалтай.

- Бензин шатахууны үнийн өсөлтийг валютын ханшаас болсон хэмээн Монголбанкийг буруутгах хүмүүс байна. Үүнтэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдоржийг огцруулах тухай санал Ардчилсан намаас гарсан.

- Ханшийн өөрчлөлт бензиний үнэд нөлөөлсөн эсэх асуудлаар УИХ-ын ажлын хэсэг дүгнэлтээ гаргаад ямар ч холбоогүй болохыг тогтоосон. Сүүлийн 12 сарын статистикийг харахад ам.долларын ханш хамгийн ихдээ 11.7 хувиар л чангарсан байгаа. Харин мөн хугацаанд ОХУ-аас авах бензиний импортын үнэ 50 гаруй хувиар өссөн байх жишээтэй. Эндээс бензиний үнэ гадаад зах зээлээс болов уу аль эсвэл ханшаас болов уу гэдэг нь тодорхой харагдах байх. Гэтэл үүнийг улс төржүүлж Монголбанкны удирдлагатай хариуцлага тооцно гээд байгааг ойлгохгүй байна. Төсөв улс төржихийн сөрөг үр дагаврыг бүгд харж байсан. Үүн дээр нэмээд мөнгөний бодлогыг улс төржүүлээд эхлэх юм бол юу болохыг төсөөлөхөд ч бэрх.

- “Ам.долларын ханшийг тогтвортой хэмжээнд буулган валютын зах дээрх ам.долларын хомсдолыг арилгах арга хэмжээ авч” ажиллахыг Засгийн газраас Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржид зөвлөсөн юм байна.

- УИХ-аас баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн 1.2-т “Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг баримтална” хэмээн тов тодорхой заасан байгаа. Монголбанк энэ хүрээнд ханшийн бодлогоо хэрэгжүүлнэ.

- Уян хатан тогтоно гэхээр ханш хөдөлж байна гэсэн үг үү?

- Монголбанк нэг талаас валютын зах дээр үүссэн түр зуурын шинжтэй ханшийн хөдөлгөөнийг зохицуулах, нөгөө талаас эрэлт нийлүүлэлт хөдөлсөн нөхцөлд ханшийг шинэ тэнцвэр лүү аль болох аядуу, зөөлөн хүргэх бодлого баримтлана. Түүнээс биш ханшийг хүчээр тогтоон барихгүй. 2008-2009 оны хямрал эхлэхээс өмнө 1 ам.долларын ханш 1145 төгрөгтэй тэнцэж байсныг санаж байгаа байх. Гэтэл зэсийн үнэ навс унаснаар төгрөгийн ханшин дээр асар их дарамт ирсэн. Төгрөгөө хамгаалж байна гэж хагас жил хүрэхгүй хугацаанд валютын нөөцийнхөө бараг талыг алдаад эцэс сүүлд нь ханшаа чөлөөлөхөд 1700 төгрөг хүртэл харваж байсан. Уг нь ханшийг тухай бүр хэлбэлзэх боломжийг нь олгож байсан бол магадгүй 1400 хүрээд тогтворжих байсан байх. Эцэс сүүлд нь эдийн засаг гүн хямралд ороод ОУВС-аас тусламж гуйхаас аргагүй байдалд орж байсан шүү дээ. Эдийн засгийн суурь хүчин зүйлс хөдөлсөн үед ханшийг хүчээр барих гэж оролдвол валютын нөөцөө бараад дуусдгийг олон орны жишээ гэрчилнэ.

- Сүүлийн үед долларын ханш чангарсныг Монголбанк юу гэж тайлбарлаж байгаа вэ?

- Ханшийн хөдөлгөөн, ерөнхий хандлагыг харъя гэвэл валютын орох, гарах урсгалаа л харьцуулаад үзчих хэрэгтэй. Өнгөрсөн онд манай улсын валютын орох урсгал 40 хувиар, харин гарах урсгал 75 хувиар нэмэгдсэн байна. Тэгэхээр төгрөгийн ханш сулрах дарамт ирэх нь ойлгомжтой байгаа биз. Манай улсын гадаад худалдааны нөхцөл төдийлөн таатай бус байна. Зэс, нүүрсний экспортын үнэ зогсонги байдалтай болчихлоо. Гэтэл нөгөө талдаа нефтийн үнэ буурах хандлага мөн ажиглагдахгүй байна. Ираны асуудал тойрсон нөхцөл байдал нефтийн захын тодорхойгүй байдлыг улам нэмэгдүүлэхээр байна. Гадаад худалдааны алдагдал гэхэд л 2011 оны эцэст 1.7 тэрбум ам.доллар байх жишээтэй. АНУ, Европын холбооны эдийн засгийн төлөв байдал ихээхэн тодорхойгүй байгаа нь хөрөнгө оруулагчдын шийдвэрийг хойшлуулах, түдгэлзүүлэхэд хүргэж байна. Энэ бүхэн төгрөгийн ханш сулрах нөхцөл болсон.

- Ханшийг хөөргөхгүй байх бүхий л арга хэмжээг Монголбанкнаас авсан гэж та хэлж чадах уу?

- Би дээр хэлсэн, Монголбанк ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх байдлаар валютын захад интервенц хийдэг гэж. Монголбанк 7 хоног бүрийн Мягмар, Пүрэв гаригт валют авах, зарах дуудлага худалдааг зохион байгуулдаг. 2008-2009 оны хямралыг гэтлэн давахад тус дуудлага худалдааг идэвхтэй хэрэглэж байгаад эдийн засаг тогтворжихын хэрээр бид оролцоогоо түр зогсоогоод байсан юм. Харин өнгөрсөн оны 11 дүгээр сараас хойш интервенцийг дахин хийж эхэлсэн ба энэ зориулалтаар өдгөө хүртэл 300 гаруй сая долларыг зараад байна. Өнгөрсөн долоо хоногийн хувьд бол бид ажлын бүх өдөр интервенци хийж ажилласан. Валютын дуудлага худалдаанд хамаарах бүхий л мэдээг манай цахим хуудасны статистик мэдээлэл дотроос олж харж болно.

Х.ТҮВШИНТӨГС